



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ХӨВСГӨЛ АЙМАГ
2016 ОНЫ 12 ДУГААР САР**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сар

Нэг. Ерөнхий зүйл

Хөвсгөл аймгийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэн, МУ-ын Ерөнхий аудиторт Хөвсгөл аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд 11 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж 230,7 сая төгрөгийн төсвийн зарлага гаргасан байна.

Аймгийн аудитын газар нь 2016 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн аудит 10-г, нийцлийн аудит 9-ыг гүйцэтгэж, санхүүгийн тайлангийн аудитаар 86 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 300 байгууллагыг аудитын түүвэрт хамруулан, 48 байгууллагын санхүүгийн тайланд засврын аудит хийж ажилласан байна.
- Тайлант хугацаанд нийт 598 зөвлөмж бүртгэснээс 461 буюу 77 хувийн биелэлтийг хангуулан бүртгэсэн байна.
- Тайлант хугацаанд 30.2 тэр бум төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 1.3 тэр бум төгрөгийг залруулж, 38.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг таслах зогсоох 1,6 тэр бум төгрөгийн албан шаардлага тавьж орон нутгийн орлогод 94,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.
- Төлбөрийн актын биелэлт 99.0 хувь, албан шаардлагын биелэлт 99.0 хувь байна.
- Гүйцэтгэсэн аудитаар нийт 34.3 тэрбум төгрөгийн үр өгөөж бүртгэж харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ажиллав.

Хоёр. Санхүүгийн аудитын талаар

2.1 Санхүүгийн аудитын талаар

Төсвийн байгууллагууд болон ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгч ажиллав.

Аймгийн аудитын газар нь Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд аймгийн аудитын газрын гүйцэтгэх аудитын хэмжээнд ашиглалаа.

2015 оны санхүүгийн тайланд Ихэр мөрөн Аудит ХХК, Эрдэм батламж аудит ХХК, Ньюбаланс аудит ХХКомпаниуд 201 байгууллагын санхүүгийн тайланд гэрээний дагуу аудитыг гүйцэтгэж, аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар нь бусад 169 байгууллагуудад аудитыг стандарт, журам, гарын авлага, арга зүйн дагуу хийж 86 дүгнэлт гарган 501 цаг ажилласан байна.

Аудитаар 86 байгууллагад санал дүгнэлт гаргаснаас 4 байгууллага /Мэргэжил сургулт үйлдвэрлэлийн төв, Мөрөн сумын ТТЗ, Мөрөн нисэх буудал, Их уул дулаан ОНӨААТҮГазар/ “Хязгаарлалттай” санал дүгнэлт, бусад 82 байгууллага буюу 95,3 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 6696,4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 1314,1 сая төгрөгийн алдааг залруулж, 7,7 сая төгрөгийн төлбөрийн акт, 89,2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 22 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар 239 зөвлөмж хүргүүлсэн байна.

Ерөнхий аудиторовын 2016 оны А/72 тушаалын дагуу 179 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гарган, 164 байгууллагыг аудитын түүвэрт хамруулах, 8 байгууллагад итгэл үзүүлэхээр төлөвлөн 49 байгууллагын санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгэв.

2.2 Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн салбарийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 19 сумын Эрүүл мэндийн төв, Биеийн тамир спортын газар, 5 өрхийн эмнэлэг нийт 25 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

2.3 Боловсрол, соёлын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар Хөвсгөл аймгийн Боловсрол, соёлын салбарийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Ерөнхий боловсролын сургуулийн 37 байгууллага, СӨБ-ийн 42 байгууллага, соёлын 26 байгууллагын нийт 105 санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитаар Сумдын ЕБС-ууд дотуур байрны нэг хүүхдийн хоолны нормативт зардлыг 36,86-379,33 төгрөгөөр буюу нийт 1887,8-10013,5 мянган төгрөгөөр, үдийн цайны нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг 31,57-190 төгрөгөөр буюу нийт 1664,5-5211,8 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн, нэг хүүхдийн хоолны нормативт зардлыг 142,38-446 төгрөгөөр нийт 5026,1-9173,5 мянган төгрөгөөр дутуу олгосон, хүүхдийн цэцэрлэгүүд нэг хүүхдийн хоолны нормативт зардлыг 110-184 төгрөгөөр буюу нийт 1894,5-5920,2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан зөрчил илэрсэн.

2.4 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн талаар

АТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нийт 356 байгууллага хамрагдсан байна. Аудитаар дараах нийтлэг зөрчил илэрсэн.

- Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 146 алдаа зөрчилтэй холбогдуулан 4431,2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд аудитын хугацаанд 12,3 хувийг буюу 547,3 сая төгрөгийн алдааг залрууллаа.
- Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн 52,1 хувь буюу 2311,9 сая төгрөг нь орон нутгийн байгууллага болон сумдын ТЕЗ-ийн байгууллагуудад, 47,8 хувь буюу 2119,3 сая төгрөг нь ОНӨААҮГ-уудын санхүүгийн тайланд илэрснээс аудитын хугацаанд зөрчлийн 12,3 хувь буюу 547,3 сая төгрөгийг санхүүгийн тайланд залруулсан байна.

- Илэрсэн алдаа зөрчлийн дүн өмнөх онд 4209,0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч байсан бол 2015 онд 55 хувиар буурсан байна.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ҮАГазрын нэгдсэн удирдамжаар 7 гүйцэтгэлийн аудит, АИТХ-ын захилгаар 3 аудит хийж, иргэний өргөдлийн дагуу 1 аудит нийт 11 гүйцэтгэлийн аудит гүйцэтгэсэн байна. 2016 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар 14,1 сая төгрөгийн төлбөрийн акт, 308,4 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 58 зөвлөмж өгч, 34,3 тэрбум төгрөгийн үр өгөөж тооцлоо.

Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудит

3.1. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д аудитыг 02 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 20 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн тайлан, судалгааг ҮАГ-т хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь нэмэгдэж “Санхүүжилт дутуу” гэдэг үндэслэлээр хуулийн хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Аймгийн БОАЖГ-ын барилгын төсөв 564.5 сая төгрөгөөр батлагдсан ч магадлалаар 867.6 сая төгрөг болсон.
- Ханх сумын сургуулийн дотуур байрны төсөвт өртөг нь хуулиар 2011 онд магадлалаар баталгаажсан дүн болох 1061.0 сая төгрөгөөр төсөвт тусгагдсан ч 2015 онд захиалагч, гүйцэтгэгч нарын баталгаажуулснаар ажлын гүйцэтгэл 1407.8 сая төгрөг болсон. 2015 оны байдлаар 1177.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Гэрээт хугацаанд барилга угсралтын ажлыг дуусгаагүйгээс гэрээний хугацааг өөрчлөн төсөвт өртөг нь нэмэгдэж, ашиглалтанд орох хугацаа хойшилж үр өгөөжөө өгөхгүй төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал: Хүнс, барааны худалдааны төв

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжих төсөл, арга хэмжээнд олгох санхүүжилтын 57.8 хувийг олгосон байна. Үлдэгдэл санхүүжилтийг Сангийн яамнаас санхүүжилтын эрх нээгээгүйгээс тайлант онд олгогдоогүй байна.

Аудитаар 673.4 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэн ба зөрчил, дүнд үндэслэн дүгнэлт гарган холбогдох байгууллагуудад 13 зөвлөмж хүргүүлж ажиллав.

3.2. “Хөвсгөл аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл” –д аудитыг 2016 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 15-ний хугацаанд хийлээ.

Аудитаар илэрсэн гол зөрчил нь:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар, төсөвт байгууллагын өөрийн орлого, халамжийн сангийн зарлагыг үндэслэлгүй төлөвлөсөн, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг зориулалт бус зүйлд зарцуулсан байна.
2. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 13969,8 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 12269,9 сая төгрөг болж 1699,9 сая төгрөг

зарцуулагдаагүй байна. Үүнээс санхүүгийн дэмжлэгийн дутуу санхүүжилт 594,2 сая төгрөг, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл **1072,7** сая төгрөг, үүнийг ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр болгон зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2015 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д зааснаар хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний үр нөлөөнд дүгнэлт хийгээгүй, зөвхөн хөтөлбөрт зарцуулсан зардлын гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Аудитаар 1372,7 сая төгрөгийн 6 зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгах үүднээс төсвийн захирагч бүрээр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн түвшинг тодорхойлон, шинжилгээ хийж, түүнд нийцүүлэн орон нутгийн төсөв батлах, орон нутгийн орлогыг бодитой төлөвлөх, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, нэмэлт төсвийн зарим хэсэг буюу Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасан орлогыг төлөвлөж, төлөвлөсөн хэмжээнд зарцуулж, тухайн нэр төрлөөр нь тайлагнах, сургалтын цөм хөтөлбөртэй уялдуулан Нутгийн аваргууд болон Авьяас сургуулийн анги дүүргэлт, багш нарын цагийн нормативийн гүйцэтгэлд судалгаа хийж, хөтөлбөрийн үр дүнг сайжруулан төсвийн үр ашгийг дээшлүүлж ажиллах талаар зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад 5 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

3.3. “Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын дүн” аудитыг 2016 оны 04 дугаар сарын 01- нээс 05 дугаар сарын 20-ны хугацаанд хийж Үндэсний аудитын газарт удирдамжийн дагуу судалгаа, тайлбар гарган хүргүүлсэн.

Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт үр дүнд нийсэн гүйцэтгэлийн аудитаар 3,9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлсэн ба зөрчил, дүнд үндэслэн дүгнэлт гарган Улсын нөөцийн салбарын даргад 2 зөвлөмж хүргүүлж ажиллав. /Уг аудит нь төрийн нууцын түвшинд хийгдсэн болно/

3.4 Орон нутгийн ИТХ сонгох сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох

Орон нутгийн ИТХ сонгох сонгуулийн зардлыг хуульд заасан зардлын төрлөөр тогтоон тооцон Хөвсгөл аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/6 дугаар тушаалаар сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг нам, эвсэл 222,0 сая төгрөг, нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 19,0-35,0 сая төгрөг байхаар тогтоов.

3.4. “Аймгийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэл” гүйцэтгэлийн аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэн ҮАГ-т хүргүүлэн ажиллав. Хөвсгөл аймаг ээлжит сонгуульд нийт 540,0 сая төгрөг зарцуулсан байна. Аудитаар 33,2 сая төгрөгийн зөрчил илрүүлэн зөрчлийг арилгах 2,2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэн ажиллав.

3.5 “Орон нутгийн төсвийн төсөл болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн ИТХ-д оруулах” гүйцэтгэлийн аудитаар Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга орлого нэмэгдүүлэх 207,9 сая төгрөгийн, зардал бууруулах 287,6 сая төгрөгийн, төсвийн үр ашиг нэмэгдүүлэх санал

хүргүүлэн, төсвийн төсөл дэх 31 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх санал хэрэгжсэн байна.

3.6 Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулах" гүйцэтгэлийн аудитыг сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд гүйцэтгэн нийтэд мэдээлэн ажиллав.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд 36 тойрог, 41 мандатад 5 нам, 94 нэр дэвшигч оролцсон байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон МАНам, АНам, намаас болон бие даан нэр дэвшсэн 84 нэр дэвшигчийн /АН-37, МАН-41, Эх орон нам-2, Ард түмнээ хайрлая нам-3, Бие даагч-1/ сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулав.

Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон, зардлын тайлан ирүүлсэн намууд, нэр дэвшигчид нийт дүнгээр 440,0 сая төгрөгийг сонгуульд зарцуулсан байна.

ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

3.7 Аймгийн ИТХ-ын хүсэлтийн дагуу аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны **“Аймгийн ИТХ-аас баталж 2015 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн”** гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэж үр дүнг АИТХ, аймгийн Засаг Даргад танилцуулан ажиллаа.

3.8 Аймгийн ИТХ-ын хүсэлтийн дагуу **“Дулааны станц, дулаан шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа ААТТӨҮГ-ын санхүүгийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа”** гүйцэтгэлийн аудит хийж үр дүнг АИТХ, аймгийн Засаг Даргад танилцуулан ажиллаа.

3.9 Аймгийн ИТХ-ын хүсэлтийн дагуу **“Цахим засаг, үндэсний хөтөлбөр, өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”** гүйцэтгэлийн аудит хийв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал дараах байдалтай байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар сумдын Засаг дарга нарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн бөгөөд сумдын ЗДТГ тендерийн баримт бичгийг боловсруулаагүй, гүйцэтгэгчээр ажилласан компаниуд техникийн нөхцөл, ажлын даалгаврыг боловсруулсан байв.

Шинэ-Идэр, Улаан-Уул, Алаг-Эрдэнэ сумдад харьцуулалтын аргаар тендер зохион байгуулах байсан ч гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан байна.

Шилэн кабель суурилуулах ажил бүрэн хэрэгжсэн ч ТЭЗҮ хийгдээгүй, төсвийн зохицуулалт хийгдээгүйгээс сумдын зарим байгууллагууд интернетийн төлбөр төлөхөд батлагдсан урсгал зардлын төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар нийт 14.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байна. Ашиглалтгүй байгаа тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар захиалагч, ашиглагчийн зүгээс ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна. Аудитаар илэрсэн зөрчил, дүнд үндэслэн дүгнэлт гарган холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

3.10 “Нийгмийн халамжийн үйлчилгээний газар, халамжийн сангийн үйл ажиллагааг иргэний өргөдлийн дагуу шалгах ” гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө хөтөлбөр гарган өргөдөлд дурдсан асуудлуудаар шалгасан болно.

Аудитаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн нэмэгдлийг 2016 оны 4, 5, 6 дугаар саруудад нөхөж олгосон ба 5200 төгрөгийг 1880 хүнд 9.776.0 мянган төгрөг, 11500 төгрөгийг 2316 хүнд 26.634.0 мянган төгрөг бүгд 4196 хүнд 36.410.0 мянган төгрөг олгосон ба 1460 иргэнд /давхардсан тоогоор/ 11,490,0 мянган төгрөгийг олгоогүй, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сонгон шалгаруулалт журмын дагуу явагдаагүй зэрэг зөрчил илэрсэн байна

Иргэний өргөдөлд дурдсан асуудлаар гүйцэтгэлийн аудит хийж МУ-ын Ерөнхий аудитор болон өргөдөл гаргасан иргэн, аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлэн ажиллав.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГазрын нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу 9 нийцлийн аудит гүйцэтгэн ажиллаа. Нийцлийн аудитаар 5,1 сая төгрөгийн төлбөрийн акт, 1446,5 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 51 зөвлөмж өгч ажиллаа.

4.1. Монгол улсын Ерөнхий аудиторовн баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт”** –д аудитыг 2016 оны 02 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний хугацаанд хийлээ.

Монгол улсын 2015 оны төсвийн тухай хуульд Хөвсгөл аймгийн ОНХСанд ОНХНС-гаас 8728,8 сая төгрөг олгохоор баталсан боловч төсвийн тодотголоор 5492,9 сая төгрөг болж 3235,9 сая төгрөгөөр буурч батлагдсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 төсөл, арга хэмжээ нь иргэдийн саналаар дэмжигдсэн, эрэмбэлэгдсэн, зураг төсөв нь урьдчилан боловсруулагдсан байна. Харин 6 хөтөлбөр нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зураг төсөв нь урьдчилан боловсруулагдаагүй байна.

ОНХНСангийн орлогын шилжүүлгээр 5492,9 сая төгрөг санхүүжигдэхээс 919,7 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэнээр Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт 86,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төсвөөс олгох 1369,2 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байгаа ч тулган баталгаажуулалтаар зардлыг хэмнэх замаар бий болгосон 1233,7 сая төгрөгийн эх үүсвэрээс 17,4 сая төгрөг нь зардлын хэмнэлт, 1216,3 сая төгрөг нь халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

2014 онд гүйцэтгэсэн аудитаар өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ аудитаар 5,1 сая төгрөгийн 2 акт, 1446,3 сая төгрөгийн 9 албан шаардлага, хариуцлага тооцуулах санал 9-ыг холбогдох газруудад нь хүргүүлсэн.

4.2. Монгол улсын Ерөнхий аудиторовн баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах”** –д аудитыг 2016 оны 04 дугаар сарын 20-нээс 04 дугаар сарын 28-ний хугацаанд хийлээ.

Үндэсний аудитын газрын харъяа аймгийн Аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд улс

төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрт нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаанд нийт 9 албан шаардлагыг улс төрийн нам, бие даан нэр дэвшигч нарт хүргүүлж, сонгуулийн мөрийн хөтөлбөрт холбогдох хууль зүйд нийцүүлэн залруулга хийхийг шаардаж ажилласан.

Аудитын хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн 6 нам, 8 бие даан нэр дэвшигч нарын нийт 14 сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж ажилласан болно.

4.3. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”** –д аудитыг 2016 оны 02 дугаар сарын 01-нээс 04 дугаар сарын 30-ний хугацаанд хийлээ.

Нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд мэдээллээ байршуулсан эсэхийг хянан шалгалаа.

Аудитад улсын төсвийн 37, орон нутгийн төсвийн 177 байгууллага, 25 төсвийн ерөнхийлөн захирагч, 5 төрийн өмчит үйлдвэрийн газар, 46 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 1, нийт **291** байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хяналт хийлээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим хуудсаас гадна **khovsgol.gov.mn, tusuv-oronnutag.mn** цахим хуудсанд ил тод мэдээллэж хэвшсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн 9 сумын **17** байгууллагад албан шаардлага хүргүүлэн **6216.2** төгрөгийн зөрчлийг аудитын явцад арилгуулан зөвлөмж өгч ажиллалаа.

4.4 Сумын ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийсэн нийцлийн аудит

Хөвсгөл аймгийн орон нутгийн сонгуульд оролцох МАН болон Ардчилсан намын тус бүр 23, МҮАН, Эх орон намын тус бүр 1, бие даан нэр дэвшигч 61 буюу нийт 109 мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулахаар аудитын байгууллагад ирүүлж дүгнэлт гаргууллаа.

Аудитаар намуудын мөрийн хөтөлбөр 33, бие даан нэр дэвшигч иргэний 9 мөрийн хөтөлбөрт албан шаардлага хүргүүлэн залруулах арга хэмжээ авч ажиллав.

4.5 Сумын ИТХ сонгох сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох нийцлийн аудит

Сумын ИТХ сонгох сонгуулийн зардлыг хуульд заасан зардлын төрлөөр тогтоон тооцон Орон нутгийн иргэдийн хурлын 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн А/25 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн сумдын сонгуулийн иргэдийн

хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигч, нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 9,0-12,0 сая төгрөгөөр тогтоосон байна.

4.6 Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн /Байгаль хамгаалах сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан/

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар тодорхойлогдсон “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”, “Байгаль орчныг хамгаалах сан”-гуудын үйл ажиллагаа, сангаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгав.

2015 оноос эхлэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын Засаг даргын тамгын газрын төсөвт хөтөлбөрөөр төлөвлөгдөж хэрэгжих болсон тул “Байгаль хамгаалах сан”-д төсвөөс өгөх санхүүжилт 2015 оноос зогсоогдсон байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-аас 2015 онд аймгийн МСҮТ-ийн 170037401 тоот дансанд 191.8 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж, 187.7 сая төгрөгийг тэтгэлэгт зарцуулсан гэж тайлагнасан байна. Үүнд: Сургалтын програмын үнэнд 14.5 сая төгрөг, даатгалд 2.5 сая төгрөг, МСҮТ-ийн суралцагчдад 170.7 сая төгрөгийг тэтгэлэг хэлбэрээр тус тус олгосон байна. 2015 оны сүүлийн улирал болон 2016 оны эхний 6 сарын тэтгэлгийг харьяа яамнаас суралцагч тус бүрийн хувийн дансанд шилжүүлсэн байна.

4.7 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитыг нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн аудитын тайлан, судалгааны хамт Нийцлийн аудитын газарт хүргүүлсэн. Тус аудитын дүн дүгнэлтэд үндэслэн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар, аймгийн Засаг дарга, санхүү хяналт, аудитын албаны дарга, байгууллагуудын дарга нягтлан бодогч нарт нийт 5 зөвлөмж хүргүүлэн ажилласан. Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заагдсан 292 байгууллагыг хамруулан нийт 11741,8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, 2 байгууллагад албан шаардлага хүргүүлэн ажилласан.

4.8 “Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитыг нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн аудитын тайлан, судалгааг ҮАГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллав..

Хөвсгөл аймаг 2015 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 958,5 сая төгрөгийг төлөвлөн, төсвийн тодотголоор 1014,2 сая төгрөг болгон өөрчилсөн байна. Баталсан төлөвлөгөөгөөр сумын санал 265681,1 мянган төгрөгөөр, БОАЖГ-ын санал 43576,8 мянган төгрөгөөр тус тус дутуу, жилийн дундуур хийсэн тодотголоос аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан нь 55725,9 мянган төгрөгөөр бага байгаа нь төсвийг үндэслэлгүй, боломжит тоо хэмжээ, нөөц, хэрэгцээ шаардлагад тулгуурлахгүй төлөвлөж байгааг харуулж байна.

Тайлант жилд нийт 480,5 сая төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл хөрөнгийг санхүүжилтийн эрх нээгээгүйгээс тайлант жилд зарцуулаагүй байна.

Хяналт шалгалтыг үе шаттай хэрэгжүүлж байгаа боловч илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгаагүй, холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авч ажиллахгүй байгаа тул дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нийцлийн аудитаар дахин илэрч байна.

Аудитаар 461,3 сая төгрөгийн зөрчил илрүүлэн аудитын тайланг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллав

4.9 “Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл” нийцлийн аудитыг нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу

Аймгийн Сонгуулийн хороо улсын төсвөөс сонгуулийн зардалд хуваарилагдаж ирсэн 483,8 сая төгрөгөөс 469,2 сая төгрөгийг зарцуулж, 14,6 сая төгрөгийн үлдэгдлийг СЕХ-нд буцаан төвлөрүүлсэн байна.

Тав. Дотоод ажлын талаар

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу аймгийн аудитын газрын менежер нь аудитор шинжээч нартай 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулан, гэрээний биелэлтийг дүгнэн ажиллаа.

Үндэсний аудитын газрын www.audit.mn веб сайтаар 2016 онд хийсэн бүх аудитын тайлан, дүгнэлтийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

2016 онд хийсэн аудитын хураангуйг мэдээллийн самбар болон “Эрх чөлөө сонин”-той гэрээ байгуулан нийтлүүлж мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Аймгийн ИТХурал, ИТХ-ийн тэргүүлэгчдийн хуралд 2016 онд гүйцэтгэсэн 18 аудитын тайлан хүргүүлж, тайланг хураангуйлан танилцуулж, аудиттай холбоотой авах арга хэмжээний талаар тогтоол гаргуулан ажиллав.

Байгууллагын үйл ажиллагаа, аудитын дүнг танилцуулах “Хөвсгөл аймгийн аудитын газар” Facebook хуудас ажиллуулав.

ҮАГазраас зохион байгуулсан онлайн хуралд бүрэн оролцож, мэдээ тайланг шуурхай хүргэн ажиллаж байна.

Аймгийн аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг гаргуулан авч, ХОМ-ийн тайланг Авлигатай тэмцэх тухай хуулийн дагуу 02 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т хүргүүлсэн.

2016 онд иргэдээс 16 өргөдөл, санал хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шалган хариуг албан ёсоор хүргүүллээ. Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгүүдийн дагуу шаардлагатай судалгааг хугацаанд гаргаж хүргүүлж ажиллаа.

Тайлант хугацаанд 86 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 11 гүйцэтгэлийн аудит, 11 нийцлийн аудит, аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хийж, чанарын хяналтын хуудсыг хөтөллөө.

Аудитын тайланг хувиан олшруулж 143 байгууллагад олгож, аймгийн Эрх чөлөө сонинд 8 тайлангийн хураангуй хэвлүүлэн, 11 удаа орон нутгийн телевизээр мэдээлэл хийж, 80 байгууллагад мэдээлэл, аудитын талаар танилцуулга, аудитын нээлт хийж ажилласан байна.

Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, мөрдөн ажиллаж байна. Мөн аудит эхлэх бүрд ашиг сонирхолын зөрчилгүй тухай мэдэгдэлд аудитор, шинжээч нараар гарын үсэг зуруулж баталгаажуулж, программд шивж байна.

СТАУС программыг ашиглах, өөрчлөлт тохируулгын ажлын талаар Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан, аудитор Гончигцэрэн, SMART GREEN ХХК-ны захирал Одхүү нар Аудитын газрын ажилтнуудад сургалтыг 2015 оны 12 дүгээр сарын 05, 06-ний өдрүүдэд явууллаа. Уг сургалтаар программын сайжруулалтын талаар харилцан ярилцлаа.

Аудитын газрын хамт олон 4-р сард аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль болон 2015-2016 онуудад шинээр батлагдсан хуулиудын талаар 2 өдрийн сургалтанд хамрагдав.

Стратеги удирдлагын газраас зохион байгуулсан Аудитын олон улсын стандартын сургалт 4 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 11 ажилтан бүрэн хамрагдав.

Сэлэнгэ, Дарханы аудитын газарт очиж, тус байгууллагын туршлага судаллаа.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх Төрийн аудитын сургалтын тогтолцоог сайжруулах буюу мэргэжлийн тасралтгүй сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгаанд 11 ажилтан хамрагдан Стратегийн удирдлагын газрын ажилтнууд фокус бүлгийн ярилцлага хийв.

Зургаа. Дүгнэлт санал

2016 онд байгууллагын урсгал зардал 230,7 сая төгрөгийн батлагдсанаас 230,7 сая төгрөг зарцуулж үйл ажиллагаагаа хэвийн явууллаа.

Хөвсгөл аймгийн Аудитын газар нь 2016 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

Дараах санал, хүсэлт байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн аудитын газар нь 24 сум, төсвийн 370 гаруй байгууллагатай аудитад хамрах цар хүрээ ихтэй байдаг. Батлагдсан 11 орон тоогоор ажиллахад цар хүрээ ихтэй аудитад ажиллах аудитор, шинжээчийн ажлын ачаалал их, хүн хүч хүрэлцэхгүй байдалд хүргэж байна. Иймд манай байгууллагын орон тоог 2-оор нэмэгдүүлэх боломж нөхцлийн судлан шийдвэрлэж өгөхийг санал болгож байна.
2. Аудиторуудын хэрэглэж байгаа тоног төхөөрөмж /компьютер, зургийн аппарат/ зэрэг хуучирч, эдэлгээний хугацаа дууссан тул шинэчлэл хийхэд анхаарна уу.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР